



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Тасаг нэгжүүдийн халдварын
сэргийлэлт хяналтын баг, хяналтын
сувилагчий шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 536 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Тасаг нэгжүүдийн халдварын сэргийлэлт, хяналтын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тасаг нэгжүүдийн халдварын сэргийлэлт, хяналтын багийн ажлын чиг үүргийг хоёрдугаар, халдварын сэргийлэлт, хяналтын сувилагчийн ажлын чиг үүргийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд, халдвар хяналтын ажилтанг удирдлага, арга зүйгээр хангаж үйл ажиллагаанд нь хяналт тавьж, ажиллахыг Поликлиникийн эрхлэгч (Д.Молор-Эрдэнэ), Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч (Б.Намуунбайгаль), Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга (Ж.Үнэнбаяр), лабораторийн эмч (Д.Намуун) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тасаг нэгжийнхээ халдвар хамгааллын дэглэмийн үйл ажиллагаанд дотоодын хяналт тандалтыг тогтмол хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлж ажиллахыг тасаг нэгжүүдийн халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд, халдвар хяналтын ажилтнуудад үүрэг болгосугай.

4.Тасаг нэгжүүдийн халдварын сэргийлэлт, хяналтын багийн гишүүд, халдвар хяналтын ажилтнуудыг сургаж дадлагажуулан мэргэжил арга зүйгээр хангаж хамтран ажиллахыг Халдварын сэргийлэлт хяналт хариуцсан тархвар судлаач (С.Өлзийжаргал)-д үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны дарга (Д.Гэжиймаа)-д даалгасугай.

D desk 2024 a tushaal

170420733


6.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын "Тасаг нэгжүүдийн халдварын сэргийлэлт хяналтын баг, халдвар хяналтын ажилтанг томилох тухай" 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/10 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  А.СУВДАА



6033210402
042061 06721028

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
 1/7.6 дугаар тушаалын 1р хавсралт



ТАСАГ НЭГЖҮҮДИЙН ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН БАГИЙН
 БҮРЭЛДЭХҮҮН, ХАЛДВАР ХЯНАЛТЫН АЖИЛТАН

Халдварын сэргийлэлт хяналтын багийн бүрэлдэхүүн			Тасаг нэгжийн халдварын сэргийлэлт хяналтын сувилагч
Тасаг нэгжийн нэр	Багийн гмшүүдийн овог нэр	Албан тушаал	Албан тушаалаар
Поликлиник	С.Дүйнхэржав	Мэс заслын эмч	Поликлиникийн ахлах сувилагч
	Ч.Намуунцэцэг	Халдвартын эмч	
	Г.Энхжаргал	Мэс заслын сувилагч	
	Л.Уранцэцэг	Шүдний сувилагч	
	Х.Оюунбат	Дотоод шүүрлийн булчирхайн сувилагч	
Хүлээн авах хэвтэн эмчлүүлэх тасаг	Ш.Оюун-эрдэнэ	Их эмч	Хүлээн авах, хэвтэн эмчлүүлэх тасгийн ахлах сувилагч
	С.Надмид	Их эмч	
	Б.Наранхажид	Сувилагч	
	Б.Энхтүвшин	Сувилагч	
	Ш.Гэрэл	Асрагч	
НЭМА дэмжих төв	А.Түвшинтогтох	Тархвар судлаач	
	Р.Анармаа	Дурангийн эмч	
	Д.Мягмарсүрэн	ДОХ/БЗДК-ын сувилагч	
	Д.Мэнджаргал	Сүрьеэгийн сувилагч	
	Ж.Мөнхжаргал	Дурангийн сувилагч	
Лаборатори	Г.Наранцэцэг	Лаборант	
	С.Одбаяр	Лаборант	
	С.Сайханбаяр	Лаборант	

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 00 дугаар сарын 00-ны өдрийн
176 дугаар тушаалын 4р хавсралт



ТАСАГ НЭГЖҮҮДИЙН ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН БАГИЙН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

1.Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр гарсан Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвийн даргын тушаал, заавар журмуудыг мөрдөж хэрэгжүүлэн ажиллана.

2.Тасаг нэгжийнхээ үйл ажиллагааны онцлогт тохирсон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой хяналт, халдварын сэргийлэлт хяналтын төлөвлөгөөг боловсруулан тасаг нэгжийнхээ дарга эрхлэгчээр батлуулан хэрэгжүүлж ажиллана

3.Тасаг нэгжийн хэмжээндээ халдвар хамгааллын дэглэмийн байдалд Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дүгээр тушаалаар баталсан заавруудын үнэлгээний хуудсыг ашиглан дотоодын хяналт тандалтыг хийж илэрсэн зөрчлийг тухай бүр нь засуулах арга хэмжээг авч үр дүнг тасаг нэгжийнхээ эмч ажилчиддаа танилцуулна.

4.Тасаг нэгжүүдийн эмч эмнэлгийн ажилтны халдварын сэргийлэлт хяналтын мэдлэг, дадлыг сайжруулах аян, сургалт сурталчилгаа, үзүүлэх сургууль зэргийг дотооддоо зохион байгуулна.

5.Эмнэлгийн тусламж үйлчилгээ халдвар хяналтаас эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх асуудлаар тасаг нэгжийнхээ эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад Эрүүл мэндийн төвийн халдварын сэргийлэлт хяналтын албатай хамтран сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг авч ажиллана.

6.Амбулаториор үйлчлүүлэгчид болон хэвтэн эмчлүүлэгчдийн дунд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалтыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 539 дүгээр тушаалаар баталсан заавар журмын дагуу тандалтын хуудсуудаар тандалтыг хийж халдварыг эрт илрүүлэн мэдээлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

7.Нянгийн тэсвэржилттэй уялдуулан нянгийн эсрэг эм, бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж ажиллана.

8.Тасаг нэгжээр үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг өгч, үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгална.

9.Тасаг нэгжийн эмч эмнэлгийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч өртөлтийн дараах сэргийлэлтийн анхны тусламжийн цомог, асгарсан цацагдсан биологийн шингэнийг цэвэрлэж халдваргүйжүүлэх цомгийг ажилбартай кабинет, нэгж бүрт байршуулан бэлэн байдлыг хангуулан ажиллана.

10.Тасаг нэгжийн хэмжээнд шаардлагатай байгаа эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариун цэврийн материал, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн тооцоог гаргаж Эрүүл мэндийн төвийн халдварын сэргийлэлт хяналтын албанд өгнө.

11.Тасаг нэгжийнхээ эмч эмнэлгийн ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, эрүүлжүүлэх ажлыг ажилчдын эрүүл мэнд хариуцсан эмчтэй хамтран зохион байгуулна.

12.Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах халдвараас эмч эмнэлгийн ажилтнуудыг хамгаалах, уг халдвар илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулж, мэдлэг дадал олгох ажлыг тасаг нэгжийн хэмжээндээ зохион байгуулан хийнэ.

13.Тасаг нэгжийнхээ эмч эмнэлгийн ажилтныг халдвараас сэргийлэх зорилгоор шаардлагатай дархлаажуулалтанд тухай бүр нь хамруулж дархлаажуулалтын нэгдсэн бүртгэлтэй байна.

14.Тасаг нэгжид дадлага хийж байгаа оюутан, дадлагажигч эмч дадлага хийх хугацаанд халдварт өртөхөөс сэргийлж байгууллагын болон тасаг нэгжийн дотоод журам зааврыг танилцуулж, мөрдүүлнэ.

15.Ажилд шинээр орж байгаа эрүүл мэндийн ажилтанд тасаг нэгжийн хэмжээнд мөрдөн ажиллах халдвар хамгааллын дэглэмийн талаар болон мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар санамж, зөвлөгөө өгнө.

16.Халдварын сэргийлэлт хяналтын албанаас боловсруулж өгсөн тасаг, кабинетуудад цэвэрлэгээ хийх журам, цэвэрлэгээний давтамж, өдөр тутмын цэвэрлэгээнд хяналт тавьж хуудсыг тухай бүр нь хөтөлсөн эсэхэд хяналт тавьж зөрчлийг арилгуулах.

17.Тасаг нэгжүүдийн тусгай хог хаягдлын менежментийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаалаар баталсан заавар журмыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

18.Эрүүл мэндийн ажилтан цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэж сэргийлэлтийн арга хэмжээг авч ажиллана. Эрүүл мэндийн төвийн халдвар судлагч эмчид мэдээлнэ.

19.Эмнэлгээр үйлчлүүлж буй иргэд үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд халдварт өртөх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр холбогдох мэдээлэл зөвлөгөөг өгнө.

20.Эрүүл мэндийн сайдын 2019 оны 539 д дүгээр тушаалын 01 дүгээр хавсралтаар баталсан зааврын дагуу сар бүр эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, "өртөлт, дундаж хатгалтын мэдээг тухайн тасаг нэгжийн ахлах сувилагч гаргаж дараа сарын 5-ны дотор Эрүүл мэндийн төвийн халдвар судлагч эмчид өгнө.

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
1176 дугаар тушаалын 3р хавсралт



ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН СУВИЛАГЧИЙН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Халдварын сэргийлэлт хяналтын сувилагчийн ажлын зорилго: Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх.

Ажлын үндсэн зорилт:

- 1) Хяналтын сэргийлэлт, хяналтын
- 2) чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих
- 3) Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт хийх, эрт илрүүлэн мэдээлэх, хариу арга хэмжээ авах
- 4) Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авах

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

I үндсэн зорилтын хүрээнд:

1. Тасгийн халдварын сэргийлэлт хяналтын хөтөлбөр, төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэн ажиллана
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдлийг бууруулах, сэргийлэх, хянах, тасгийн эмч, эмнэлгийн ажилтны оролцоог дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулна.
3. Эрсдэл өндөртэй ажилбаруудыг хянах хуудсаар шалгадаг байна.
4. Халдвар хяналтын чиглэлээр чиглэлээр хийгдэж буй дотоодын хяналт, тандалтын ажлын тайлан мэдээг цаг тухайд нь гаргах, тасгийн эмч, ажилтнуудад танилцуулах, эмнэлгийн халдвар судлаачид өгнө.
5. Тасгийн эмч, ажилтнуудын:
 - 5.1. Гар угаах, халдваргүйжүүлэх
 - 5.2. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг зөв, зохистой хэрэглэх
 - 5.3. Хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах
 - 5.4. Цусаар дамжих халдвараас сэргийлэх
 - 5.5. Багаж хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх
 - 5.6. Ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг найруулах, хэрэглэх асуудалд хяналт тавьж, хэрэгжүүлнэ.

II үндсэн зорилтын хүрээнд:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, халдвар хяналтыг илрүүлэх тандалтыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 539 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу хийх, мэдээлэх үйл ажиллагааг холбогдох эмч мэргэжилтнүүдтэй хамтран хийх
2. Үйлчлүүлэгч болон тасгийн эмч, мэргэжилтэнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэх, арилгуулах арга хэмжээг авах

III үндсэн зорилтын хүрээнд:

1. Тасгийнхаа эмч ажилчдыг дархлаажуулалтанд хамруулах, эрүүл мэндийн байдалд хяналт тавих, үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулна.
2. Эрүүл мэндийн ажилтан цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, өртөлтийн дараах арга хэмжээг авч ажиллана.